

# Монголын орон нутгийн мэдээ

АЗИЙН БҮСИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛИЙН ЗАХИАС БИЧИГ

## Христийн Мэндэлсний баярын жинхэнэ утга учир

Далын Ахлагч Жуи-Чанг Хуан

**И**хэнх хүмүүсийн хувьд Христийн Мэндэлсний баяр нь зүгээр л нэг баярын өдөр байдаг. Хүүхдүүд Христийн Мэндэлсний баярын бэлгээ хүсэн хүлээж, насанд хүрэгчид худалдаа наймаагаа хийж, залуу хүмүүс үдэшлэг зохион оройг хүртэл наадан цэнгэлддэг билээ. Зарим нэг хүмүүсийн хувьд энэ нь ямар ч онцгой зүйлгүй жирийн л нэг өдөр. Харин цөөн хүмүүс л энэхүү баярын үнэн шалтгаан болсон Есүс Христийн тухай тунгаан боддог.

Намайг Гадасны ерөнхийлөгчөөр үйлчилж байхад нэгэн тойрог Христийн Мэндэлсний баярын үдэшлэг зохион байгуулсныг би санаж байна. Хоол идсэний дараа хэдэн бүжгийн үзүүлбэрүүд явагдсан бөгөөд тэдгээр нь зохисгүй мэт надад санагдсан. Есүс Христийн Сүмийн гишүүдийн хувьд, бид энэхүү онцгой өдрийг хэрхэн тэмдэглэх хэрэгтэй вэ гэдгийг би бодож эхэлсэн.

Номлолын Ерөнхийлөгч бид хоёр хэлэлцээд мөн зарим илчлэлийг хүлээн авсныхаа дараа, олон хүмүүс цуглардаг Вү Күан Чапелийн машины зогсоол дээр Христийн Мэндэлсний баярын жинхэнэ утга учрыг харуулсан тоглолт хийхээр шийдсэн юм. Сүмийн гишүүд болон номлогч нар дуу хөгжим ба жүжигчилсэн тоглолтоор дамжуулан Есүс Христийн төрөлтийн түүхийг гишүүд болон тэдний урьсан хүмүүст түүнчлэн гадаа явж байсан хүмүүст энэ хүйтэн өдөр Христийн Мэндэлсний баярын тоглолтыг үзүүлсэн билээ.



Ахлагч  
Жуи-Чанг Хуан

Дараа нь сүмийн байранд орж тэдэнд зориулан бэлтгэсэн Христийн Мэндэлсний баярын тухай үзэсгэлэнг үзэх боломжийг олгосон юм. Энэхүү уламжлал олон жилийн турш үргэлжилсээр байгаа бөгөөд бидний бэлтгэсэн тоглолтууд олон хүний сэтгэл зүрхэнд хүрч,

сайн мэдээг сонсон, сүмийн гишүүн болоход нөлөөлсөн юм. Бид Христийн төрөлтийг ийнхүү тэмдэглэдэг болсонд би баяртай байдаг. Жил бүр Сүмийн олон гишүүд би ч бас энэхүү онцгой өдөр ирэхийг тэсэн ядан хүлээдэг. Нэг удаа Христийн Мэндэлсний баяраар бид тоглолтоо илүү бодит болгохын тулд тэмээ хөлсөлж билээ. Бид уг тэмээг гадаах хаалганы хажууд байлгасан тул гадуур явж байсан хүмүүс ихэд сонирхон цугларсан ч дотогшоо орж бидний тоглолтыг үзээгүй юм. Дараагийн жил нь бид тэмээг дахин авахгүй байхаар шийдэж билээ.

Гадаадын нэгэн гэр бүл надаас өнчин хүүхдийн асрах газар эсвэл тусламж хэрэгтэй байгаа өөр бусад газрыг мэдэх үү хэмээн асуусан. Христийн Мэндэлсний Баярын өдөр ядуу бөгөөд тусламж хэрэгтэй хүмүүст туслах нь тэдний гэр бүлийн уламжлал ажээ. Тэд Христийн Мэндэлсний Баярын жинхэнэ утга учрыг үнэ-

хээр ойлгодог хэмээн би боддог. Сүмийн нэгэн удирдагч Христийн Мэндэлсний баяраар өөр нэгэн удирдагчийг санаандгүй гомдоосон тухайгаа надтай хуваалцаж билээ. Хэдийгээр энэ нь түүний буруу биш байсан ч, Христийн Мэндэлсний баярын үдэш тэрээр Ариун Сүнийг мэдэрч, өөрийгөө зоригжуулан, өөрийн гомдоосон өнөөх удирдагч дээр өршөөлийг асуухаар нүдэндээ нулимстайгаар очсон байна. Тийн эвийг сахигч байснаараа тэр Есүс Христэд хамгийн агуу бэлэг өгсөн гэдэгтээ итгэдэг.

Учир нь Христ бол Энх Амгалангийн Ханхүү тул бид түүний жишээг даган, Христийн үнэн гэгээнтэн болохын тулд тууштайгаар хичээх хэрэгтэй.

Хавай дахь Бригам Янгийн Их Сургуульд оюутан байхдаа би бишоптойгоо тусламж хэрэгтэй хүмүүст бэлэг тараахаар хамт явдаг байлаа. Би Сүмийн гишүүдийн хаалганы дэргэд бэлгийг нь тавьж, хонхыг нь дараад машин руугаа гүйдэг байлаа. Тэгээд дараагийн айлд очин мөн л үүнийгээ давтана. Сүмийн хоньчдын хувьд бид энэ бишопын жишээнээс сурч болно. Хэрвээ, Сүнсний илчлэлтээр бид хамтрагч нарыг (ялангуяа залуу эрэгтэй болон залуу эмэгтэйчүүдийг) өөрсөдтэйгээ авчирч чадах юм бол, бид Христийн Мэндэлсний баярын элч нар болж, Христийн хайрыг түүний эрхэм хайртай хүүхдүүдэд нь илгээх болно. Бэлгийг хүлээн авч байгаа мөн түүнийг өгч байгаа тэдгээр нь агуу баяр баясал болон хичээл зүтгэлийнхээ үр шимийг хүлээн авдаг.

Христийн Мэндэлсний Баярын дууллыг сонсох болгонд, миний зүрх сэтгэл Ариун Сүнсээр дүүрдэг. Эдгээр дуулуудыг бичсэн яруу найрагч болон хөгжмийг зохиогч нь Христийн даруухан шавь нар бөгөөд тэдэнд Аврагчийг хайрлах гүн гүнзгий хайр байдаг гэдгийг би мэднэ. Сүнсний удирдамжийн дор тэд эдгээр сайхан, сэтгэлд хүрэм үгсийг бичсэн билээ. Хэдийгээр бид Христийн Мэндэлсний баярын дуулуудыг зөвхөн Христийн Мэндэлсний баярын үеэр л дуулдаг ч, тэдгээрийн гайхамшигт сайхан аялгуу нь бидний чихэнд бүтэн жилийн турш сонсогдсоор байдаг. Тэнгэрлэг Эцэгийн Хүү Есүс Христ энэ дэлхийд төрсөн гэдгийг би гэрчилж байна. Энэ бол Эцэгийн бидэнд зориулсан агуу их хайрын илэрхийлэл юм (Иохан 3:16). Христ бидний төлөө төрсөн мөн бидний төлөө амиа өгсөн. Түүний ажил, заасан зүйлүүд мөн гайхамшгууд нэг бүр нь биднийг амьдралын тэрхүү хамгийн агуу бэлгүүд рүү хөтөлдөг. Би түүний шавь байгаадаа мөн Христийн Мэндэлсний баярын жинхэнэ утга учрыг мэдэж байгаадаа талархаж байна. Энэ жилийн Христийн Мэндэлсний баяраар, Түүний үнэнч шавь нар болцгоон, Аврагчдаа хамгийн агуу бэлгийг өгцгөөе. ■

## Анхны гар тэрэгтэй Залуучуудын чуулган

Энхтайван тойргийн гишүүн Ц.Батцацрал

Улаанбаатар баруун гадасны Залуучуудын чуулган 2012 оны мясгийн уриа болох “*Босч мөн урагш гэрэлтүүл*” хэмээх Сургаал ба Гэрээ 115:5 дээр бичигдсэн судрын эшлэлийг аяныхаа уриа болгосон юм. Аяны гол зорилго нь Сионыг байгуулахын төлөөх Анхдагч нарын гайхалтай үлгэр жишээ, тэдний туулсан зовлон бэрхшээлийг аялалынхаа явцад ухааран мэдрэх байсан бөгөөд амьдралдаа тулгарах элдэв саад бэрхшээлийг энд мэдэрсэн сүнслэг хүчээр давж, суралцсан зарчим бүрийг ирээдүйн Бүрэн цагийн номлогч байхад, Ариун сүмийн нандин ёслолуудыг хүлээн авахад бэлтгэх явдал байлаа. Монголд анх удаагаа зохион байгуулагдаж байгаа гар тэрэгний энэ аялал зуны дэлгэр сайхан цагт 2012 оны 6 сарын 18-наас 23-ны өдрүүдэд Хайлантайн ам хэмээх байгалийн

үзэсгэлэн төгөлдөр сайхан нутагт зохион байгуулагдсан юм. Залуус гар тэрэг түрээд явах ямар ч туршлагагүй байлаа. Тэд очсон газартаа хурдан дассан ч гар тэргээ түрээд буудалласан газраасаа хөдлөх үед үл мэдэх газраар, ямар бартааг туулан алхахаа мэдэхгүй байсан тул хүн бүр нэг л догдолсон гайхсан байдалтай байлаа. “Эхний гар тэрэг замаас салаад ой дундуур яв” гэсэн хөтчийн зааврын дагуу тэд аянаа эхлэв. Тэд тэргээ түрэн, хол алхаж хөлөө холгуулан, наранд халахаас эмээгээгүй ч харин бяцхан ялаа, шавьж тэдний асуудал болж байлаа. Аялалын турш тэд “Ирцгээ, Ирцгээ гэгээнтнүүд ээ” дууг урамтайгаар дуулж, анхдагчдын мэдрэмжийг бага ч болов мэдэрч явлаа. Уул өөд гар тэргээ түрэн гаргасны дараа “Аялах зам тань бартаатай санагдавч, Амьдрал тань ивээгдэнэ” гэсэн дууны үгс тэдний зүрх сэтгэлд



Бид хэзээ ч ялагдашгүй



амлалт болон тайвшруулж байв. Гар тэрэгний аялалд оролцсон хүүхдүүд гэрчлэхдээ, “Анхдагч нарын туулсан аялалын багахан хэсгийг ч гэсэн мэдэрсэндээ баяртай байна.” Гар тэргээ шаварт суухад нь бие биеэндээ тусалж, хамтын хүчээр аливаа саадыг

**Уулын уруу нэлээд хүч, тэвчээрийг шаардлаа**

**Нэгдмэл хүч бүхнийг дийлнэ**



**Зөвхөн урагшаа!**

даван, урагшилсаар байлаа. Уулын уруу, модон дундуур, ямар ч зам байхгүй газраар мод сүлжин бууж, том жалгаар гарч, хааяа нэг шаварт гутлаа, углаашаа гэж тэдгээрийг хайж, энд тэнд хүүхдүүдийн хөл шаварт шигдэж явлаа. Өдрийн хоолонд багахан арвайн гурил идэж, хээр бороотойд хоол хийж идэх нь шалгуур байсан ч шөлтэй хоол нь устай борооноос болж улам их шөлтэй болох нь хөгжилтэй байлаа. Залуус уулыг өгсөж,

модон гүүрээр гаран, саад бартаа болгоныг давсаар буудаллаж байсан газартаа урамтайяа ирцгээв. Бүгдийн сэтгэлд хамгийн хүчтэйгээр үлдсэн зүйл нь задгай түүдэг гал тойрон суугаад гэрчлэлээ хуваалцсан явдал байлаа. Дараагийн өдөр нь зам дагуу тэднийг Хялганат суурингийн хажуугаар гарч явтал нутгийн иргэд замыг

нь хааж, замаар явуулахгүй гэсэн боловч Их Эзэн тэдэнтэй хамт байсан тул Түүний бас нэгэн гайхамшгийг тэд мэдрэх боломжтой байжээ. Өргөн уудам тал нутгаар явсаар Сэлэнгэ голыг гатлан, тэнд хоол хийж идэн, хэсэг зуур амсхийсний дараа буцаж, голоо гатлан буудалласан газар руугаа буцах замд гуталны олом нь тасарч хөл нүцгэн явах зарим нь байсан ч саад болгоныг ямар ч гомдолгүйгээр даван, бие биенээ дэмжиж явлаа. Аялалын турш тэднийг Бурхан адислаж мөн хамгаалж байлаа. “Эдгээр туршлагауд Бурханы агуу нигүүлслийг ухаарахад тусалсан бөгөөд анхдагч нарын туулсан зовлон бэрхшээлийг зах зухаас нь ч болтугай ойлгоход тусалсан” хэмээн залуучууд гэрчилж байна. Тэд гар тэрэгний аялалаар дамжуулан тэвчээртэй байхыг, эв нэгдэлтэй байвал хамтдаа юуг ч хийж чаддагийг мөн зорилготой байж үүндээ хүрэхийн төлөө ухаалгаар тэмцэх хэрэгтэй гэдгийг зүрх сэтгэлдээ мэдэрснээ хуваалцаж байна. ■



# Монгол Улаанбаатар Номлолын Чуулган

**М**онгол Улаанбаатар Номлол нь нийт номлогчдынхоо чуулганд Дaлын Чуулгын Ахлагч С.Скотт Гроу ахыг халуун дотноор хүлээн авлаа. Тэрээр хүн бүр идэвхгүй болсон нэг гишүүнийг идэвхжүүлэх амлаат авахыг уриалаад олон сайхан зөвлөмжийг бидэнд үлдээлээ. Мөн Гроу эгч Сүмд хэн ч хэн нэгнийг санаатайгаар гомдоодоггүй. Харин бид өөрсдөө гомдохыг сонгосноор бусдад гомддог болохыг минь сануулав. Ерөнхийлөгч Кларк бүх номлогч нарыг хамтын сургалтаа хийж, “*Миний Сайн Мэдээг Номло*” удирдамжаас суралцаж, өдөр бүр Номлогчийн хувьд миний гол зорилго юу вэ? Бидэнд гишүүд туслах үүрэгтэй юу эсвэл бид гишүүдэд туслах үүрэгтэй юу? гэж асууж, залбирахдаа Хиламан 10:4-5-ыг санан, Бурханы тааллын эсрэг биш зүйлийг гуй, тэгвэл юу хүссэнээ авах болно хэмээн заалаа. Кларк эгч хамтрагчийгаа хайрлаж, Ариун Сүнс үйлдлийг тань хөтлөхийг хүлээн зөвшөөрөх нь үр дүнтэй нэгдмэл байдлыг бий болгогчийг сануулав. Ерөнхийлөгч Одгэрэл бидэнд сонирхогчдыг өөртөө биш Есүс Христэд хөрвүүл гэж хэлсэн юм. Цуглаан болгоны дараа сонирхогчид тань ямар нэгэн сайхан сэтгэгдэлтэй байх хэрэгтэй гэдгийг Ерөнхийлөгч Бат-Оргил бидэнд анхааруулсан. Хийх хэрэгтэй зүйлсээ бүү хойшлаул. Хэрэв үүнийг хийхийг хүсэхгүй бол бид шийтгэгдэх болно, тэгээд заавал түүнийгээ хийх хэрэгтэй болно гэсэн үг гэлээ. Ахлагч Хант 43 жилийн өмнө номлолд үйлчилж байсныг нь бодвол номлолын ажил арга барилын хувьд сайжирсаныг дурсаад, хамгийн агуу номлогчдын нэг Аммон бөгөөд тэр зааж эхлэхээсээ өмнө Лемонай хааны итгэлийг олж, нэгэнт итгэлийг олж авсан тул тэрээр хаан болон түүний гэр бүл, бүр цаашлаад хаант улсад нь заадаг. Номлолын ажлын энэ хэсэг хэзээ ч өөрчлөгдөөгүйг хэллээ. Бүрэн



*Ахлагч Гроу номлогчидтой гар барьж байгаа нь*

цагийн номлолоосоо бууж буй 19 номлогч байлаа. Тэд бүгд гэрчлэлээ хуваалцах боломжтой байсан юм. Тэдний ихэнх нь номлолын цаг хугацаа маш хурдан өнгөрдөг болохоор үйлчлэх хугацаандаа хамгийн сайнаараа хичээж ажиллахыг номлогч бүрт захьж байлаа. Номлогч бүр гайхалтай удирдамжийг авсан бөгөөд Их Эзэний захиасыг тунхагласнаар үр дүнг нь үзэх болно. “Чи хэн болохыг хүсч байна?” гэсэн асуултыг дор бүрнээ тунгаан бодож, зорилго тавин, Христийг дагаарай хэмээсэн Ахлагч Гроу-гийн захиасыг санан, хэрэгжүүлдгээе. ■

*УБ Номлолын Ерөнхийлөгч Кларк номлогчдод зааж байгаа нь*



# Залуучуудын чуулган Чойбалсанд

Хант эгч

Бүгдээрээ маргааш машины ил зогсоол дээр өглөөний гурван цагт уулзацгаая! гэсэн зарлалыг Чойбалсан дахь тавин таван залуус сонссон бөгөөд энэ нь 2012 оны долоодугаар сар байв. Чуулганы хоёр дахь өдөр өглөө эрт уулзалдаад, Чойбалсан хотын нар мандахыг харахаар явлаа. Би орчуулагчдаа хандан, “Үнэхээр сонирхолтой байна. Хэдэн хүн ирэх бол доо. . . Магадгүй арав орчим л байх гэж би бодож байна” гэхэд орчуулагч маань надад, “Миний бодлоор таны гайхашралыг төрүүлэх байх” гэлээ. Үнэхээр тийм зүйл болж, гайхашралыг минь төрүүлэн дөчин залуус бидэнтэй хамт өглөөний нар мандахыг үзэхээр ирсэн юм. Чуулганы маань уриа “Бос, бас Гэрэлтэн явцгаая” байсан бөгөөд үзэсгэлэнтэй нар мандахыг харсаны дараа үүнийг илүү сайн ойлгон мэдэрч байлаа. Чуулганы нээлтэн дээр үг хэлсэн хүн бүр “гэрэл” мөн “хэрхэн чамаас гэрэл цацардаг” талаар ярьсан юм. Залуучууд хэдэн багт хуваагдан, хэрхэн гэрэл цацардаг талаар ямар нэгэн зүйл хийж тоглов. Бүгд уран сэтгэмжийн тоглоомд оролцож, хөгжилдөж байлаа. Гадаа олсоор хийсэн аварга аалзны тор байрлуулж, түүгээр явах гэж оролдов. Тэд олсны аль ч хэсэгт хүрч болохгүй байсан бөгөөд тэд даалгаврыг биелүүлэхийн тулд болгоомжтойгоор дээш өгсөх хэрэгтэй байлаа.



Хамтдаа хөгжилдөн дуулцгаая



Үзэсгэлэнтэй нар мандалт

Үүнийг зайлшгүй багаар үйлдэх шаардлагатай байсан ба багууд аварга том аалзны шүлсний нүхээр гулсан, бие биенээ өргөж хамтдаа ажиллаж байв. Харин сүнслэг үйл ажиллагаанд залуучууд багаар хуваагдан, баг бүр сүнслэг хичээлүүдэд тойрон оролцов. Тэд хувийн үнэ цэнэ, болзоо, ариун сүмийн гэрлэлт зэрэг сэдвээр суралцаж, оройны гэрчлэлийн цуглаан дээр олон залуус сурсан зүйлийнхээ талаар, Есүс Христийн талаар гэрчлэлээ хуваалцаж, амьдралдаа хэр зэрэг Есүс Христийг хайрладаг тухай чин сэтгэлийн үгсээ хэлсэн юм. ■



Хөгжилтэй мөч

# Дэээрэт Олон Улсын Энэрлийн Байгууллагын Үйл Ажиллагаанаас

2012 оны “Ногоо тарих” мөн “Бага мал үржүүлэх” төсөл амжилттайгаар хэрэгжлээ

Тус Байгууллага хөдөө орон нутаг болон хотын салбар тойргуудаас ирсэн ногоо тарих төслийн зохицуулагч нарт зориулсан сургалтыг Баянзүрх байрны 3-р давхарт 2012 оны 3 сарын 22- 23-ны өдрүүдэд зохион байгуулав. Дэээрэт уг сургалтанд яригдах лекц, гарын авлага гэх мэт материал бүхий хавтсуудыг тэдэнд зориулан бэлтгэсэн байсан бөгөөд өглөөний болон үдийн хоолоор хангасан юм. Хоёр салбараас бусад сүмийн бүх нэгжийг төлөөлөн ногооны төслийн зохицуулагч нар ирж, оролцлоо. Холоос ирсэн хүмүүсийн унаа, хоол, зочид буудалд байрлах зардлыг Дэээрэтээс хангав. Төсөлд оролцож буй 466 оролцогчдод зориулан тус бүр нэг ногоо тарих болон амьтан тэжээх гарын авлагыг хуваарилан өглөө. Энэхүү төслийг өглөгч тусархаг хүмүүсийн сайн дурын хандиваар бүрддэг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Хүмүүнлэгийн сангаас санхүүжүүлж байгаа билээ. Энэхүү сургалт нь амьтан өсгөж үржүүлэх, хөрс бэлтгэх, усалгааны систем, хадгалалт, ногоогоо хэрхэн тарьж, арчлах, үр хурааж авч хадгалах, хүлэмж болон бие даан амьдрахын гол зорилго гэх мэт 19 сэдвийн дагуу явагдсан юм. Хаалтын үйл ажиллагаанд Ерөнхийлөгч Жэй Кларк оролцож, ням гарагийн ангийн багшийн тухай нэгэн түүх яриу. Багш хичээлдээ архи, тамхи, шоколад, шороогоор дүүргэсэн дөрвөн шил авчран шил тус бүрт чийгийн улаан хорхой хийжээ. Эхний гурван шилэн дэх хорхойнууд тэр даруй үхэж, дөрөв дэх шилэнд байсан хорхой үхсэнгүй. Тэгээд багш “За, та нар үүнээс юу суралцсан бэ?” гэж асуухад нэг эмэгтэй “Хэрэв бид архи ууж, тамхи татаж, шоколад идвэл гэдсэндээ хорхойгүй байх юм байна” гэжээ. Хариулт нь “буруу” байлаа. Та бүхэн энэ сургалтаас ногоо хэрхэн тарих болон хэрхэн бие



Хүлэмжиндээ

даан амьдрах талаар сурсан байх гэж найдаж байна хэмээн ерөнхийлөгч ярьсан юм.

1. Дэээрэтийн захирал Ахлагч Ричардсон Ногооны төслийн зохицуулагч нарыг тавтай морилохыг уриад, хүмүүнлэгийн сангийн мөнгө хаанаас орж ирдгийг сануулсан юм. Энэ нь Их Эзэний мөнгө бөгөөд үүнийг бид бусдын хүслийг хангахад биш, хэрэгцээнд нь зориулан зарцуулах хэрэгтэй. Тэрээр түүнчлэн дуслын усалгааны систем, хүлэмж, насосны талаар ярьж, төсвийг нь тайлбарлаж өгсөн юм.

2. Монголын Фермер Эмэгтэйчүүдийн холбооноос багш нар ирж, ногоогоо хэрхэн сайн ургуулж, арвижуулах талаар заав. Тэд хүлэмж, ил талбай, хайрцаглаж зассан талбайн арга техникийн ялгааг тайлбарлалаа.

3. Монголын фермер эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн Бяцхандаа багш хүнсний ногооны бүтээгдэхүүний талаар маш их мэдлэгтэй, өндөр боловсролтой, чадварлаг нэгэн. Ногоо тарьж байгаа хүмүүс түүний зөвлөгөөг дагавал сайн ногоочин болно доо.

4. Монгол Фермер сургуулийн багш Б.Энхдолгор жижиг амьтад буюу тахиа, туулай, гахайг хэрхэн тэжээж, арчлах талаар заалаа. Тэрээр тахианы үүдэрүүдийн ялгаа, ямар төрлийн тахиаг (махны, өндөгний эсвэл өндөг-махны чиглэлийн) тэжээхэд илүү ашигтай талаар заав. Түүнчлэн өөр өөр төрлийн байр барьж болох талаар яриу.

5. Насанболд ах өнгөрсөн жил анх удаагаа хүлэмж барьж ногоо тарьсан юм. Тэр өөрийн туршлага болон алдаанаас ярьж, зөвлөгөө өгсөн.

6. Улаанбаатар Баруун гадасны 2-р зөвлөх Ерөнхийлөгч Н.Адьяаболд бидэнд хүнсний бүтээгдэхүүний сүнслэг байдлын талаар, Их Эзэн яагаад биднийг бие даан амьдрах төлөвлөгөөг нь дагаасай хэмээн хүсдэг талаар заасан юм. Эцэг

эхчүүд хүүхдүүдээ дураар нь байлгаж, хүссэн бүхнээр нь ханган, хөрөнгөө дэмий үрэн таран хийж алдаа гаргаж байгаад нь бид харамсаж байна. Та хүүхдүүдээ хүссэн бүгдээр нь хангаж чадахгүй. Эх сурвалж нь юу ч байсан эцэг эхийн өгдөг



**Чойбалсан дахь ногооны талбай**

тэтгэмж бол тэтгэмж л юм. Өөрсдийн ур чадвараа ашиглан өөрсөддөө баялгийг бүтээцгээ хэмээн Ерөнхийлөгч Н.Адьяабодд яриу.

7. Хант эгч хайрцаглаж зассан талбай, ялмаг бэлтгэх, саванд ногоо тарих талаар заалаа. Харин Ц.Наранчимэг эгч нүхэн зооринд ногоогоо хэрхэн хадгалах болон ногоо дарах, хатаах талаар ярьсан юм. Өөрсдөө хөдөлмөрлөн бие даан амьдарцгаая!

8. ХААЯ-аас ирсэн Оюунчимэг багш хөрсийг хэрхэн бэлтгэх, нарны гэрлийг хэрхэн ашиглах, бордох, зэрлэг ургамлыг хянаж, ургуулахгүй байх, услах, ногоогоо тарьж ургуулах талаар хичээлүүдийг заасан.

9. Наранцэцэг багш хүлэмжинд ногоог хэрхэн тарьж ургуулах талаар заасан. Тэр бүх төрлийн ногооны талаар ярьсан ба улаан лооль, өргөст хэмхийн талаар түлхүү мэдээлэл өгөв.

10. Улаанбаатар Зүүн дүүргийн ерөнхийлөгчийн 2-р зөвлөх Баярдэлгэр ах бие даах чадварын зарчмын талаар яриу. Тэрээр өөрийн бага нас болон хангалуун амьдралтай айлын хүүхэд байсан тухай түүхээ хуваалцсан юм. Монголд зах зээл орж ирэхэд тэрээр ажлаа алдсан бөгөөд тэр үед хүмүүс гэр бүлээ хоол хүнс, хувцас хунараар хэрхэн хангахаа сайн мэдэхгүй байлаа. Ийм юм болно гэж хүмүүсийн санаанд ч ороогүй байсан болохоор Засгийн Газраа түшиглэж байв. Түүний гэр бүл сүмд элсэн орсноор амьдралын зөв зарчмуудыг сурч, гэр бүл нь илүү сайн болж өөрчлөгдсөн бөгөөд бие даах чадвар нь тэдний хандлагыг өөрчилсөн хэмээн ярьж байлаа.

Энэ төслийн хүрээнд Ричардсон ах эгч хоёр олон газраар, орон нутгаар аялж, газар дээр нь төсөлд хамрагдсан гэр бүл болоод хувь хүмүүстэй уулзан, үр дүнгээ шалган, нэмэлт ямар

нэгэн хэрэгцээ буйг асуун, төслийнхөө үр дүн болоод оролцогсдын амжилтыг харж, сэтгэл хангалуун байлаа. Тэд Чойбалсан, Дархан, Эрдэнэт, Зүүнхараа, Ховд, Булган, Мөрөн болоод Улаанбаатарын дүүргүүдээр явж, олон гэгээнтнүүдээрээ бахархаж байв. Тийм ээ, өөрсдөөс шалтгаалах бүхнийг хийж, өөртөө болон бусдад тустай, бие даан амьдарцгаая!

### **Монголын хараа зүйн төлөвлөгөө гаргах хороо, 2012 оны 3-р сарын 30**

ДОУЭнэрлийн байгууллага нүдний эмч нартай уулзаж, Эрүүл Мэндийн Яам, Их Хурал болон Улсын Нийгмийн Даатгалын Ерөнхий газарт танилцуулах төлөвлөгөөний талаар хэлэлцлээ. Энэхүү төлөвлөгөө нь хараа муудаж сохор болох, нүдний даралт, чихрийн шижингийн ретинопати болон бусад харааны согогтой холбоотой асуудлыг Монгол Улс хэрхэн шийдвэрлэх тухай заалт юм. Уг төлөвлөгөө батлагдвал энэ нь Монголд хараа зүйг сайжруулах үйл ажиллагааны гол чиглэл болох юм. Тэд мэдээлэл, сургалт, урьдчилсан стандарт, бүх эмнэлэгт байх тоног төхөөрөмжийн стандарт, чихрийн шижингийн шинжилгээний удирдамж, алслагдсан аймгуудад үйлчлэх нүдний явуулын эмнэлгийн талаарх санал, хараа султай хүмүүст үйлчлэх төвийг байгуулах, телевизээр дамжуулан зөвлөгөө өгөх зэрэг хөтөлбөрүүдийг дэвшүүлэв. Монголын Хараа зүйн Нийгэмлэг (МХН) сургалтын арга барилыг аль хэдийн үндэслэн

**Мөрөнгийн Мөнхөөгийн арвин ургац**



гаргасан байсан боловч сургалтын сэдэв нь уг төлөвлөгөөгөөр тодорхойлогдсон байна. Эрүүл Мэндийн Яамны төлөвлөгөөнд заагдсан сэдвээр үйл ажиллагаа явуулах эрх бүхий эмч нарын гэрчилгээ болон Тасралтгүй Боловсролд анхаарч зохицуулах болно. ДОУЭ-ийн Байгууллага нь уг төслийн талаар төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажилладаг эмч нартай уулзаж, шаардлагатай тоног төхөөрөмж,

мэдлэг боловсрол олж авч, эзэмшихэд нь туслах боломжтой юм. ДОУЭ-ийн Байгууллага нь Монголын хараа зүйн салбарыг илүү сайжруулахад туслах зорилгоо олон жилийн турш хэрэгжүүлж байгаа тул Хараа зүйн төлөвлөгөө гаргах хорооны байнгын гишүүн болох саналыг хүлээн авсан юм. Жон Бостон ахын цуглуулж хандивласан нүдний шилнүүдийг авахаар Ховд болон Чойбалсан аймгаас ирсэн нүдний эмч нар манай офист ирсэн юм. Энэ хоёр аймаг Улаанбаатар хотоос алслагдмал байрлалтай, хүн ам олонтой учир сонгогдсон билээ.

### Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засварчин, 2012 оны 5-р сарын 18

Монголд ирж 1-р эмнэлэг дээр тоног төхөөрөмжийн засварчдад сургалт өгөх тухай ДОУЭ-ийн Байгууллагаас гаргасан хүсэлтийг Карл болон Тера Кларк нар хүлээн авч, Монголд ирсэн юм. Нэгдсэн 1-р эмнэлгийн Зүрх судас, үе мөчний тасгийн эрхлэгч Батболдтой бид уулзсан тэр үеэс л энэхүү төсөл яригдаж эхэлсэн билээ. Эмнэлгийн тоног төхөөрөмж хандивлах талаар ярилцаж байх үед өөрсдөд нь байгаа тоног төхөөрөмжийг засаад, ашиглаж чадахгүй байгаа эмнэлгүүдэд Дэээрэт яагаад шинэ төхөөрөмж хандивлах хэрэгтэй билээ гэсэн асуулт гарч ирсэн юм. Халамжийн Санд хандивлагдсан хуучин тоног төхөөрөмжүүдийг хүмүүнлэгийн хэлтэстэй хамтран засдаг байсан Карл Кларк Монголд ирэх саналыг хүлээн авч, Монгол Улсад 90 хоногийн хугацаанд ажиллахаар ирлээ. Инженерүүдийн цахилгааны талаарх мэдлэг болон тэд хэчнээн ухаалаг, авхаалжтай болохыг хараад тэрээр гайхширчээ. Тэдэнд чанартай багаж хэрэгсэл, энгийн сэлбэг хэрэгсэл дутагдалтай байлаа. Карл тэдэнд тоног төхөөрөмжүүдийг хэрхэн гагнаж, шингэлэгч ашиглан засах, тусгай гагнуурын хошуу яагаад чухал болон хүнсний сода ашиглан баттерейг хэрхэн цэвэрлэх талаар заав. Тэдний баг (эмнэлгийн засварчид) одоогоор 19 аппарат, тоног төхөөрөмж засаад байгаа бөгөөд тэдгээр



**Карл, 1-р эмнэлгийн инженер Ганбатын хамт**

засвар авахааргүй болсон байсан тул Карл сэлбэг болгон ашигласан нь дээр гэж түүнд зөвлөжээ. Засварчид, инженерүүдтэй ярьж байхдаа Карл тэдний засварладаг энгийн арга техно-



**Тера эгч англи хэл зааж байгаа нь**

логийг өөрчлөлгүй, харин ямар төхөөрөмжид илүү засвар шаардлагатай, аль төхөөрөмжинд бага засвар шаардагддаг талаар хэлж зөвлөж байлаа. 2015 онд шинээр ашиглалтанд орох эмнэлэг баригдаж байгаа бөгөөд эмнэлгийн тоног төхөөрөмжийн хяналт, тохиргооны төв байгуулахад нь Карл тэдэнд тусалж байгаа

юм. Үүнд тулгарч байгаа нэгэн том асуудал бол гарын авлагуудыг орчуулах болоод байна. Дэлхий даяарх олон улс орон машин тоног төхөөрөмж хандивлаж байгаа бөгөөд гарын авлагуудын ихэнх хувь нь хандивласан улсуудын хэл дээр бичигдсэн байгаа бөгөөд нэг нь ч Монгол хэл дээр биш, маш цөөхөн нь Англи хэл дээр хэвлэгдсэн байв.

Энэхүү төсөл нь Монгол Улсын нийт 2,754,000 гаруй хүн амд ашиг тусаа өгөх юм. Учир нь Карл Кларкийг ирэхээс өмнө Зүрх судас, үе мөчний төв клиникт хэвийн ажилладаг дефибрилятор нэг ч байгаагүй гэж бид сонссон.

Тера Кларк тус эмнэлгийн эмч, сувилагч нарт Англи хэл зааж өдрийг завгүй өнгөрүүлдэг бөгөөд тэр долоо хоногийн 4 өдөр 2-3 удаа нэг цагийн хичээл заадаг. Тера эгч хүн нэг бүртэй ажиллах дуртай. ■



**Карл ажил дээрээ**